



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/202

Хэрлэн сум

**Захирамжийн хавсралтад  
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн, ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/28 тоот тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын 2018 оны А/24 дугаар захирамжийн хавсралтын 1,2,3,9 дугаартай сургуулиудын нэршлийг өөрчилсүгэй.
- 2.Сургуулийн шинэ нэршлийн задаргааг хавсралтаар баталсугай.
- 3.Бичиг баримтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж улсын бүртгэлд бүртгүүлэхийг сургуулийн захирал нарт даалгасугай.
- 4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
дугаар сарын...-ны өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

Нэршил

№	Одоогийн нэр	Сургуулийн шинэ нэршил
1	Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургууль	Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль
2	Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын Тэмүүжин цогцолбор сургууль	Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын Тэмүүжин сургууль
3	Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын Хан Хэнтий цогцолбор сургууль	Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын Хан Хэнтий сургууль
4	Хэнтий аймгийн Бор-өндөр сумын ерөнхий боловсролын Бор-өндөр цогцолбор сургууль	Хэнтий аймгийн Бор-өндөр сумын ерөнхий боловсролын Бор-өндөр сургууль
5	Хэнтий аймгийн Бор-өндөр сумын Их-ирээдүй бага сургууль	Хэнтий аймгийн Бор-өндөр сумын ерөнхий боловсролын Их-ирээдүй сургууль
6	Хэнтий аймгийн Бор-өндөр сумын Бор-өндөр бага сургууль	Хэнтий аймгийн Бор-өндөр сумын ерөнхий боловсролын Оюуны-Уурхай сургууль